

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ**

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2017.12.20

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин үр дүн, /хөрөнгийн хэмжээ/		Биелэлт
			2017 он		
			зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО</b>					
1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.		Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	Улсын хэмжээний нэгдсэн дүнгийн мөрөөр авах арга хэмжээ тодорхой болох	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж дараах шийдвэр гарсан байна. Үүнд Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх-7 тогтоол /15 байгууллагын 269,029,698 төгрөгийн хөрөнгө шилжүүлэх/, Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох-3 /17 байгууллагын 24 ширхэг хөрөнгө худалдах/ Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох-2 тогтоол /3 байгууллагын 33,520,000 төгрөгийн хөрөнгө бэлтгэх/ Хөрөнгө актлах-6 тогтоол /31 байгууллагын 722,383,459 төгрөгийн хөрөнгө актлах/	100
5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ	6	Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	Төсвийн зардал буурах	2017 оны жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн харилцааны асуудал хэлэлцсэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 12 удаагийн хурлаар 24 тогтоол гарснаас Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх-7 тогтоол, Худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох-3 тогтоол, Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох-2 тогтоол, Хөрөнгө актлах-6 тогтоол, Өмч хөрөнгөтэй холбоотой бусад-6 тогтоол тус тус гарсан байна.	100

шатанд гаргана.	7	Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах	Тоо, төрлийг тогтоох, зардал хэмнэгдэх	Орон нутгийн өмчит байгууллагуудад нийт 6,952,505,869.14 төгрөгийн 556 ширхэг тээврийн хэрэгсэл байна. Жип-16, Дунд гарын жип-56, Жижиг суудлын машин-5 автобус-11, УАЗ машин- 125 Трактор- 30 , Зил130- 4 Портер, пронтер-52, Хүнд даац-10 Мотоцель-290, Чиргүүл-27	100	
	8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох	Хөрөнгийн бүртгэл, дуудлага худалдааг цахим хэлбэрт шилжүүлэх бэлтгэл хангагдах	Орон нутгийн өмчит 212 байгууллагын үндсэн хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн системд бүртгэлжүүлэн ажиллаж байна.	100	
5.2.2. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.	1	Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах	Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх	Завхан аймгийн Ургамал сумын хойд урд модон гүүр барих, Эрдэнэхайрхан сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажил, Цагаанхайрхан сумын цэцэрлэгийн барилгын усан хангамж, Алдархаан сумын Алаг ууланд G-Mobile -ийн антенн суурилуулах ажил, Идэр сумын Идэрийн голын гүүр барих тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлаж зохион байгуулсан. Худалдан авах ажиллагааны программ шинэчлэгдэхтэй холбогдуулан 2017 оны эхний 4-н сард Цахим худалдан авах ажиллагааг түр зогсоосон. 2017 оны 05 дугаар сараас эхлэн шинэчилсэн цахим программ ашиглалтанд орсон. 2018 оноос худалдан авах ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	70	
	2	Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлж, баяжуулах	Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний судалгаа хийж, холбогдох журам, заавар батлуулах, худалдан авах ажиллагаанд хяналт тавих	Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах журам 2017 оны 7-р сард шинэчлэгдсэнтэй холбогдуулан Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, бүтээгдэхүүний судалгааг хийж, 2018 онд Ерөнхий гэрээгээр бараа ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	100	
	<b>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ</b>					<b>95</b>